ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Хөлөнбуйр сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДОА-2025/011/НА-СТА-ТТЗ**

Цахим хуудас:
www.audit.mn
Чойбалсан хот
2025 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер: И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Нармандах
Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn
Аудитор: Б.Одхүү
Утас: 7058-4207, Цахим хаяг: odkuu@audit.gov.mn

*Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.*

# Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ..... 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..... 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан ..... 6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 8
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..... 9
5.1 Албан шаардлага .....
5.2 Зөвлөмж ..... 17
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ..... 108

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал |
| ТТЗ | Төсвийн төвлөрүүлэн захирагч |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.03.24 № 419

танай ______________-ны № ________________-т

ХӨЛӨНБУЙР СУМЫН ЗАСАГ ДАРГА Ю.ЦЭПЭЛМАА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөлөнбуйр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөлөнбуйр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 03/06 дугаар тогтоолоор “хангалттай” гэж дүгнэсэн байна.

011022213

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **622,273.8** | **800,637.8** |
| 31 | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 204,686.8 | 433,716.4 |
| 33 | **АВЛАГА** | 207,220.1 | 158,730.8 |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 210,366.9 | 208,190.6 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,531,043.6** | **4,523,199.9** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 4,531,043.6 | 4,523,199.9 |
| 39200 | **Биет хөрөнгө** | 4,428,026.4 | 4,386,274.8 |
| 39300 | **Биет бус хөрөнгө** | 103,017.2 | 136,925.1 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **5,153,317.4** | **5,323,837.7** |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,939.9** | **3,659.9** |
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 1,939.9 | 3,659.9 |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **5,151,377.5** | **5,320,177.8** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | **5,151,377.5** | **5,320,177.8** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 774,129.9 | 774,129.9 |
| 51200 | **Хуримтлагдсан үр дүн** | 4,234,778.0 | 4,403,578.3 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 142,469.6 | 142,469.6 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **5,153,317.4** | **5,323,837.7** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| I | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,652,990.3** | **4,263,092.2** |
| 11 | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **247,322.3** | **465,841.8** |
| 110 | Орлогын албан татвар | **157,535.5** | **352,299.0** |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 167,425.8 | 378,555.2 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (9,890.3) | (26,256.2) |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 77,200.1 | 79,872.8 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 12,586.7 | 33,670.0 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **511,548.6** | **452,486.8** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 511,548.6 | 452,486.8 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,894,119.4** | **3,344,763.6** |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,286,309.8** | **3,790,062.6** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,321,533.2** | **1,951,017.2** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,321,533.2** | **1,951,017.2** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 454,562.4 | 698,604.3 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 55,896.5 | 84,301.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 16,511.1 | 527,409.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 30,480.6 | 35,809.6 |
| 2105 | Нормативт зардал | 1,133.2 | 370.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 21,927.3 | 40,662.6 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 6,372.0 | 11,769.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 271,130.8 | 60,556.2 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 463,519.3 | 491,535.5 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **964,776.6** | **1,839,045.4** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **-** |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **366,680.5** | **473,029.6** |

| | | | |
|---|---|---|---|
| **IV** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | | |
| V | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **456,986.5** | **304,229.3** |
| VI | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **(90,306.0)** | **168,800.3** |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|---|
| **1** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **5,202,150.6** | | **5,202,150.6** |
| **2** | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | |
| **3** | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 5,202,150.6 | | 5,202,150.6 |
| **4** | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 39,533.0 | | 39,533.0 |
| **5** | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | | | |
| **6** | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | |
| **7** | Өмчид гарсан өөрчилөлт | | | |
| **8** | Зарласан ногдол ашиг | | | |
| **9** | Тайлант үеийн үр дүн | (90,306.0) | | (90,306.0) |
| **10** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **5,151,377.5** | | **5,151,377.5** |
| **11** | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **5,151,377.5** | | **5,151,377.5** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **5,151,377.5** | | **5,151,377.5** |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | | | |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | | | |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | |
| 17 | Өмчид гарсан өөрчилөлт | | | |
| 18 | Зарласан ногдол ашиг | | | |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 168,800.3 | | 168,800.3 |
| **20** | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **5,320,177.8** | | **5,320,177.8** |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | **2023 оны 12-р сарын 31** | **2024 оны 12-р сарын 31** |
|---|---|---|---|
| I | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,434,362.5** | **4,102,080.0** |
| 11 | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **247,322.2** | **465,841.8** |
| 110 | **Орлогын албан татвар** | **157,535.5** | **352,299.0** |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 167,425.8 | 378,555.2 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (9,890.3) | (26,256.2) |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 77,200.1 | 79,872.8 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 12,586.6 | 33,670.0 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 2,845.4 | 1,413.2 |
| 1181 | Газрын төлбөр | 9,741.2 | 32,256.8 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | | |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **292,920.9** | **648,114.6** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 292,920.9 | 340,296.3 |
| 122 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | | 307,818.3 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,894,119.4** | **2,988,123.6** |
| II | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,019,841.3** | **3,553,496.7** |

| | | | |
|---|---|---|---|
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,019,841.3** | **3,553,496.7** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,055,064.7** | **1,690,683.4** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 483,537.3 | 733,914.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 58,982.8 | 84,466.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 88,411.8 | 466,771.5 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 36,442.2 | 34,077.9 |
| 2105 | Нормативт зардал | 1,466.2 | 470.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 21,717.3 | 48,648.6 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 6,372.0 | 11,769.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 176,433.5 | 69,960.7 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 181,701.6 | 240,605.7 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 964,776.6 | 1,862,813.3 |
| III | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **414,521.2** | **548,583.3** |
| IV | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)** | **-** | **-** |
| V | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **445,785.5** | **312,573.9** |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 445,785.5 | 312,573.9 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 445,785.5 | 312,573.9 |
| 2260 | Гадаад эх үүсвэрээр | - | - |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(445,785.5)** | **(312,573.9)** |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | **(50,000.0)** | **-** |
| 14 | Бусад эх үүсвэр | - | - |
| 23 | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **50,000.0** | **-** |
| 25 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ** | **50,000.0** | **-** |
| VIII | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **(81,264.2)** | **236,009.4** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 285,951.0 | 194,394.8 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 204,686.8 | 430,404.2 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,137,326.2** | **1,826,654.2** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,622,852.0** | **1,514,080.3** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,533,565.9** | **1,463,518.5** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 719,434.8 | 685,066.7 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 90,169.9 | 84,466.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 547,938.9 | 527,409.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 33,672.6 | 33,173.9 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 57,307.1 | 57,248.6 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 11,928.9 | 11,769.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6,570.3 | 5,972.1 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 66,543.4 | 58,413.2 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **89,286.1** | **50,561.8** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 89,286.1 | 50,561.8 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 443,895.2 | 312,573.9 |

| | | | |
|---|---|---|---|
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | 70,579.0 | - |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,137,326.2** | **1,945,400.1** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | - | - |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,951,170.9 | 1,892,184.0 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 186,155.3 | 53,216.1 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 100,794.3 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 219,540.2 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **5** | **5** |
| 610001 | Төсвийн байгууллага | 5 | 5 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | 0 | 0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **24** | **24** |
| 620001 | Удирдах ажилтан | 8 | 8 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 10 | 10 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 6 | 6 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ТЗ цэвэр дүн |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **236,464.1** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **236,464.1** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **212,482.0** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **13,689.3** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **904.1** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **500.0** |
| **2105** | **Нормативт зардал** | **470.0** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **5,746.5** |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **191,172.2** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **23,982.1** |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **141,190.4** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **236,464.1** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 113,097.4 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 123,366.7 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 125.7 сая төгрөгийн 4 зөрчил[1] илэрсэнд зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгсөн.

### 3.1 Зөвлөмж

*1. Илрүүлэлт*

Сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2024 оны хөгжлийн төлөвлөгөөг 1 бодлого, 11 зорилт, 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж, биелэлтийг 90.7 хувиар тайлагнасан байна. Хөлөнбуйр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь 2024 оны 12-р сарын 30-ны өдрийн 03/06 дугаар тогтоолоор “хангалтай” гэж дүгнэсэн нь бодитой биш байна.

Үнэлгээнээс түүвэрлэн үзэхэд ОНХС-ийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 83.3 хувьтай буюу 125.7 сая төгрөгийн 3 ажил хийгдээгүй байна.

*Хөлөнбуйр сумын иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өгсөн зөвлөмж*

Сумын хөгжлийн төлөвлөгөөг үнэн бодитой үнэлж дүгнэх.

*2. Илрүүлэлт*

Сумын татварын орлого нийт дүнгээрээ 119.7 хувиар биелсэн ч үйл ажиллагааны орлого 78.4 хувьтай буюу 1.9 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 56.5 хувьтай буюу 1.1 саяар тус тус дутуу биелсэн байна. Татварын бус орлого 104.1 хувиар биелсэн ч туслах үйл ажиллагааны орлого 60.3 хувьтай 1.0 сая төгрөгөөр дутуу биелсэн байна.

Малын тоо толгойн албан татварыг 2023-2024 онуудад 65.0 сая төгрөгөөр тооцож төлөвлөөд 2023 онд 74.3 сая төгрөг, 2024 онд 70.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн нь тухайн сумын малын тоо, нэг малд ногдуулах татварын хэмжээг тооцож, мал тооллогын дүн мэдээг үндэслэн бодитой төлөвлөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй”, 41 дүгээр зүйлийн 41.2-т “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх " гэж заасантай нийцэхгүй байна.

*зөвлөмж*

Малын татварын орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөж батлуулах.

*3. Илрүүлэлт*

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд 18 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 3 төсөл, арга хэмжээ худалдан авах арга хэмжээнд иргэн, аж ахуй нэгж оролцоогүй гэсэн шалтгааны улмаас огт хэрэгжээгүй байна. Үүнд: Нийтийн ариун цэврийн байгууламж 22.9 сая төгрөг, ТАХ-ын 8 айлын орон сууц 62.8 сая төгрөг, гүний худаг 2 ширхэг 40.0 сая төгрөг. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.7-д “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

*зөвлөмж*

Төлөвлөсөн ОНХС-гийн хөрөнгө оруулалтын ажлыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах.

*4. Илрүүлэлт*

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Хоршоо хөгжүүлэх сангаас төсөл сонгон шалгаруулж зээл олгох эх үүсвэр бүрдсэн ч 2024 онд ХХС-ийн журмын дагуу төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй, зээл олгоогүй байна. Энэ нь "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 2.10 дахь "Төсөл сонгон шалгаруулах товыг зээлийн эргэн төлөлт, санхүүжилтийг харгалзан сангийн эх үүсвэрийн 15-аас доошгүй хувийг бүрдүүлсэн тохиолдолд тухайн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

*Зөвлөмж*

ХХС-ийн журмын дагуу төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулж, зээл олгох.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” заалтыг хэрэгжүүлж ажиллах. Зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| Алдаа зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Сумын хөгжлийн жилийн төлөвлөгөөг бодитой үнэлээгүй | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| Малын татварын төлөвлөгөөг бодитой тооцож төлөвлөөгүй | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| ОНХС-гийн 3 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй | 1 | 125.7 | | | | | 1 | 125.7 | | | | |
| ХХС-ийн журмын дагуу төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй, зээл олгоогүй байна. | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| **Дүн** | **4** | **125.7** | | | | | **4** | **125.7** | | | | |